ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2024/309/НА-СТА-ТШЗ**

## ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН ШИЖИР АЛТ БАГА СУРГУУЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Аудитор Ж.Бямбацогт
Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Релаэнс секюритиз Аудит” ХХК
Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт........................................................................................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .......................................................
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.......................................................................................
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа..................................................................................
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..................................................................................
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................................................
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .......................
4. Аудитын тайлан....................................................................................................................
4.1 Ерөнхий зүйл .........................................................................................................................
4.2 Материаллаг байдал ...........................................................................................................
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт...........................................................................
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....................
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..............................................
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ...........................................................................
5. Аудитын илрүүлэлт ...............................................................................................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.................................................................

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/168

танай ______________-ны № ____________________-т

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН
ШИЖИР АЛТ БАГА СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Г.ДАЙРИЙМАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Шижир алт бага сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Заамар сумын Шижир алт бага сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 хөтөлбөр 7 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж 94,5 хувиар хэрэгжүүлсэн байна

**Аудитын гол асуудал**

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход

01999297

хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **183,131,882.95** | **152,985,585.24** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 133,356,392.38 | 117,732,484.06 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 133,356,392.38 | 117,732,484.06 |
| **3121** | **Төгрөг** | 133,356,392.38 | 117,732,484.06 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 133,356,392.38 | 117,732,484.06 |
| **33** | **АВЛАГА** | 419,710.34 | 00.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 115,897.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 303,813.34 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 303,813.34 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 49,355,780.23 | 35,253,101.18 |
| **351** | **Түүхий эд материал** | 134,000.00 | 134,000.00 |
| 35130 | Эм боох материал | 134,000.00 | 134,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 49,221,780.23 | 35,119,101.18 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 96,500.00 | 96,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,325,910.00 | 1,325,910.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 996,000.00 | 996,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 46,803,370.23 | 32,700,691.18 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **787,126,570.15** | **805,725,214.11** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 787,126,570.15 | 805,725,214.11 |
| **392** | **Биет хөрөнгө** | 722,666,570.15 | 741,265,214.11 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 600,054,479.00 | 611,054,479.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -97,117,869.24 | -121,871,228.04 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 128,020,047.00 | 184,335,067.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -37,857,279.84 | -38,852,487.17 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 152,266,479.78 | 153,194,679.78 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -52,908,143.93 | -75,178,315.57 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,668,663.67 | 2,668,663.67 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -975,088.74 | -1,077,729.66 |
| 39217 | Ном | 28,515,282.45 | 26,992,085.10 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 64,460,000.00 | 64,460,000.00 |
| 39301 | Програм хангамж | 902,500.00 | 902,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -902,500.00 | -902,500.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 64,460,000.00 | 64,460,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **970,258,453.10** | **958,710,799.35** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **419,710.34** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 419,710.34 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 419,710.34 | 00.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 419,710.34 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **969,838,742.76** | **958,710,799.35** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 969,838,742.76 | 958,710,799.35 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 311,643,563.78 | 311,643,563.78 |
| 51101 | Өмч: - төрийн | 00.00 | 00.00 |
| 51102 | - хувийн | 311,643,563.78 | 311,643,563.78 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 456,123,298.65 | 444,995,355.24 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 456,123,298.65 | 456,123,298.65 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -11,127,943.41 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 202,071,880.33 | 202,071,880.33 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **970,258,453.10** | **958,710,799.35** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,356,894,066.08** | **1,228,828,177.10** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **139,605,216.08** | **62,064,577.10** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 139,605,216.08 | 62,064,577.10 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 139,605,216.08 | 62,064,577.10 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 2,386,080.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 150,648.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 139,605,216.08 | 59,527,849.10 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,217,288,850.00** | **1,166,763,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,007,730,300.00 | 1,039,381,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,007,730,300.00 | 1,039,381,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 100,694,250.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 97,891,300.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,802,950.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 108,864,300.00 | 127,382,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 108,864,300.00 | 127,382,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,101,810,582.71** | **1,213,207,055.33** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,101,810,582.71** | **1,213,207,055.33** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 887,047,457.52 | 1,115,582,384.36 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 626,844,623.30 | 774,222,383.32 |
| 210101 | Үндсэн цалин | 436,174,278.16 | 545,908,008.15 |
| 210102 | Нэмэгдэл | 150,325,889.15 | 190,364,319.22 |
| 210104 | Урамшуулал | 40,344,455.99 | 37,950,055.95 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 78,574,213.14 | 96,439,705.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,768,897.10 | 66,168,321.75 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,325,752.90 | 7,764,223.98 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,047,162.19 | 6,211,379.05 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,216,965.89 | 1,474,065.60 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,215,435.06 | 14,821,714.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 85,187,645.99 | 116,453,929.03 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,391,756.99 | 4,821,606.03 |
| 210302 | Түлш, халаалт | 77,972,409.00 | 107,961,799.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,823,480.00 | 3,670,524.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,000,000.00 | 9,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 9,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7,384,300.00 | 9,130,640.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,411,300.00 | 1,994,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,973,000.00 | 7,136,340.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 88,056,675.09 | 110,335,727.01 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,963,850.00 | 21,791,548.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,624,700.00 | 11,165,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 53,468,125.09 | 77,378,779.01 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 214,763,125.19 | 97,624,670.97 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 214,492,300.00 | 95,696,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 82,227,000.00 | 80,743,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 28,780,600.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс узүүлэх дэмжлэг | 69,110,700.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 34,374,000.00 | 14,953,100.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 270,825.19 | 1,928,070.97 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **255,083,483.37** | **15,621,121.77** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 6,680,000.00 | 26,749,065.18 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 6,680,000.00 | 17,635,440.15 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -6,680,000.00 | -26,749,065.18 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **248,403,483.37** | **-11,127,943.41** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,217,288,850.00** | **1,169,300,328.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,411,300.00** | **2,536,728.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,411,300.00 | 2,536,728.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 2,411,300.00 | 2,536,728.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,411,300.00 | 2,386,080.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,214,877,550.00** | **1,166,763,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,007,730,300.00 | 1,039,381,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,007,730,300.00 | 1,039,381,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 98,282,950.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 97,891,300.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 391,650.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 108,864,300.00 | 127,382,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 108,864,300.00 | 127,382,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,083,932,457.62** | **1,184,924,236.32** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,083,932,457.62** | **1,184,924,236.32** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **869,169,332.43** | **1,087,299,565.35** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 626,844,623.30 | 774,222,383.02 |
| 210101 | Үндсэн цалин | 436,174,278.16 | 545,908,008.15 |
| 210102 | Нэмэгдэл | 150,325,889.15 | 190,364,318.92 |
| 210104 | Урамшуулал | 40,344,455.99 | 37,950,055.95 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 78,574,213.14 | 96,439,705.30 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,768,897.10 | 66,168,321.75 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,325,752.90 | 7,764,223.98 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,047,162.19 | 6,211,379.05 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,216,965.89 | 1,474,065.90 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,215,435.06 | 14,821,714.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 85,187,645.99 | 116,453,929.03 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,391,756.99 | 4,740,906.03 |
| 210302 | Түлш, халаалт | 77,972,409.00 | 107,961,799.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,823,480.00 | 3,751,224.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,000,000.00 | 9,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 9,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7,384,300.00 | 9,662,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,411,300.00 | 1,994,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,973,000.00 | 7,668,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 70,178,550.00 | 81,520,948.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 56,957,850.00 | 70,018,548.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,220,700.00 | 11,502,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **214,763,125.19** | **97,624,670.97** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 214,492,300.00 | 95,696,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 82,227,000.00 | 80,743,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 28,780,600.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 69,110,700.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 34,374,000.00 | 14,953,100.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 270,825.19 | 1,928,070.97 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 270,825.19 | 1,928,070.97 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **133,356,392.38** | **-15,623,908.32** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 133,356,392.38 | -15,623,908.32 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 133,356,392.38 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 133,356,392.38 | 117,732,484.06 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 311,663,563.78 | 202,641,240.69 | 154,049,030.38 | 668,353,834.85 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **311,663,563.78** | **202,641,240.69** | **154,049,030.38** | 668,353,834.85 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | -20,000.00 | 00.00 | 25,764,554.97 | 25,744,554.97 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **311,643,563.78** | **202,071,880.33** | **456,123,298.65** | 969,838,742.76 |
| D01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **311,643,563.78** | **202,071,880.33** | **456,123,298.65** | 969,838,742.76 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **311,643,563.78** | **202,071,880.33** | **456,123,298.65** | 969,838,742.76 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -11,127,943.41 | -11,127,943.41 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **311,643,563.78** | **202,071,880.33** | **444,995,355.24** | 958,710,799.35 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангила | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,174,173,500.00 | 1,057,542,236.32 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,174,173,500.00 | 1,057,542,236.32 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,063,371,700.00 | 961,845,636.32 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 863,911,800.00 | 774,222,383.02 |
| 210101 | Үндсэн цалин | 570,373,000.00 | 545,908,008.15 |
| 210102 | Нэмэгдэл | 241,994,800.00 | 190,364,318.92 |
| 210104 | Урамшуулал | 51,544,000.00 | 37,950,055.95 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 107,989,100.00 | 96,439,705.30 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 73,432,300.00 | 66,168,321.75 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,639,000.00 | 7,764,223.98 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,911,700.00 | 6,211,379.05 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,728,100.00 | 1,474,065.90 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,278,000.00 | 14,821,714.62 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбө** | 7,668,300.00 | 9,662,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчил | 00.00 | 1,994,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,668,300.00 | 7,668,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 83802500.00 | 81520948.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 72,300,100.00 | 70,018,548.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,502,400.00 | 11,502,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 110801800.00 | 95696600.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 110,801,800.00 | 95,696,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 95,848,700.00 | 80,743,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 14,953,100.00 | 14,953,100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,041,547,200.00 | 1,041,918,328.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,041,547,200.00 | 1,039,381,600.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,041,547,200.00 | 1,039,381,600.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 00.00 | 2,536,728.00 |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 2,386,080.00 |
| 1E+06 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 150,648.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 133,356,392.38 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 117,732,484.06 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 39.00 | 39.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 26.00 | 26.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 12.00 | 12.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Заамар сумын Шижир алт бага сургууль нь эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, хариуцлагатай, бие даан суралцах, амьдрах чадвартай иргэн төлөвшүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус байгууллага нь Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Заамар сумын Шижир алт бага сургууль нь 2023 оныг "Сургуулийн менежментийг сайжруулах" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 12 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 92,6 хувиар биелүүлж ажилласан байна.

Төв аймгийн Заамар сумын Шижир алт бага сургууль нь 39 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,

- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал,заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна..

Төв аймгийн Заамар сумын Шижир алт бага сургууль нь тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

2023 он 11 сарын 7 өдөр аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт хамрагдсан. 94.0 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй  гэж үзлээ

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Заамар сумын Шижир алт бага сургуулийн 2023  оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон  байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Заамар сумын Шижир алт бага сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,59.6 мянган төгрөгөөр буюу 2,3 хувиар өссөн  байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| **Мөнгөн хөрөнгө** | 133,356.4 | 117,732.5 | (15,623.9) |
| **Авлага** | 419.7 | | (419.7) |
| **Урьдчилгаа** | | | |
| **Бараа материал** | 49,355.8 | 35,253.1 | (14,102.7) |
| **Үндсэн хөрөнгө** | 787,126.6 | 805,725.2 | 18,598.6 |

| | | | |
|---|---|---|---|
| **Нийт хөрөнгө** | **970,258.4** | **958,710.8** | **(11,127.9)** |
| **Өр төлбөр** | 419.7 | | (419.7) |
| **Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/** | 969,838.7 | 958,710.8 | (11,127.9) |
| **Дахин үнэлгээний зөрүү** | | | |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **970,258.4** | **958,710.8** | **(11,127.9)** |

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 15.623.9 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн цалин, нэмэгдэл зэрэг зардлууд нэмэгдсэнээс мөнгө дансны үлдэгдэл буурсан байна..

Өмнөх оны авлага дансны үлдэгдэл 419.7 мянган төгрөгийг барагдуулсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 14,102.7 мянган төгрөгөөр буурсан нь сургуулийн захирлын 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдийн А/18 тоот тушаалаар бусад хангамжийн материал данснаас 17,378.4 мянган төгрөгийн бараа материалыг акталснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данс 18,598.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь: Улсын төсвөөс 48,491.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, ном худалдаж авсан. Хандиваар 56,599.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ном зэргийг хүлээн авсан. Мөн Заамар Сумын ИТХ-н 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 04 тоот тогтоолоор 38,371.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга , ном зэргийг актлаж устгаснаас шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,041,547.2 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс 94,198.5 мянган төгрөг нийт зарлагыг 1,135,745.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 1,135,745.7 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1,169,300.3 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1.041.918.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 127,382.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс тус тус бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,182,996.1 мянган төгрөг буюу 94,3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 116,631.2 мянган төгрөгөөр, үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллыг 89,68.4 мянган төгрөгөөр, бүх төрлийн даатгалын зардлыг 11,549.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг 2,281.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | 71802-Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80226-Байр ашиглалтын үйлчилгээ | 3,067.3 | 3,067.3 | | 100.0% |
| | 80312-Сургалт семинар | 1,533.7 | 1,524.0 | (9.7) | 99,4% |
| | 81605-Эрүүл мэндийг дэмжих | 3,067.3 | 3,126.7 | 59,4 | 101,9% |
| 2 | 81801-Үдийн цай хөтөлбөр | 95.848.7 | 80.743.5 | 15.105.2 | 84.2% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **3** | 81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 38.562.5 | 38.562.5 | | 100.0% |
| **4** | 81823- Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх | 6.901.5 | 6.901.5 | | 100.0% |
| **5** | 81834- Боловсролын стандарт | 890.264.3 | 803.016.9 | 87.247.4 | 90.2% |
| **6** | 81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа хангах | 127.932.7 | 115.468.8 | 12.463.9 | 90.3% |
| **7** | 81827 бичиг үсгийн боловсролын үйлчилгээ | 4,433,5 | 2,986,0 | 1,447,4 | 67,4% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Заамар сумын Шижир алт бага сургууль нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

### *3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| | 71802-80226 | 2023-12-31 | Байр ашиглалтын үйлчилгээ | 100.0% | 3,067.3 | 3,067.3 |
| | 71802-80312 | 2023-12-31 | Сургалт семинар | 99.4% | 1,533.7 | 1,524.0 |
| **1** | 71802-81605 | 2023-12-31 | Эрүүл мэндийг дэмжих | 101.9% | 3,067.3 | 3,126.7 |
| **2** | 71802-81801 | 2023-12-31 | Үдийн цай хөтөлбөр | 84,8% | 95,848.7 | 80,743.5 |
| **3** | 71802-81816 | 2023-12-31 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 100% | 38,562.5 | 38,562.5 |
| **4** | 71802-81823 | 2023-12-31 | Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх | 100.0% | 6,901.5 | 6,901.5 |
| **5** | 71802-81834 | 2023-12-31 | Боловсролын стандарт | 90.2% | 890,264.3 | 803,016.9 |
| **6** | 71802-81835 | 2023-12-31 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа хангах | 90.3% | 127,932.7 | 115,468.8 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **7** | 71802-81827 | 2023-12-31 | Бичиг үсгийн боловсрол | 67,4% | 4,433.5 | 2,986.0 |

Бичиг үсгийн боловсрол арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь суралцагчдын ирц муу байсан нь нөлөөлсөн.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Заамар сумын Шижир алт бага сургууль нь 2023 онд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй. Аймгийн Боловсролын газраас тендерт шалгаруулсан. Номин туул сүлд ХХК, Баадуу ОПБ ХХК-аас шууд худалдан авалт хийсэн. Худалдан авах ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг батлуулж зохих хууль, журмын дагуу гүйцэтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Шижир алт бага сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Заамар сумын Шижир алт бага сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 440,000,0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 8,800.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7,040.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ажиллагсдад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Заамар сумын Шижир алт бага сургууль нь 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорх хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 89,689.4 мянган төгрөгөөр
- Нормативт зардал болон даатгалын зардлыг 11,549.4 мянган төгрөгөөр
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 2,281.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд тус Ерөнхий боловсролын сургууль нь 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 158 мэдээллийг байршуулж 1 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д ”Таван саяас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хууль, журмын заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өглөө.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Заамар сумын Шижир алт бага сургуулийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 2 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад хэрэгжээгүй 1 зөвлөмж байгаа тул аудитын тайланд зөрчлөөр тусгасан болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувь биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| **Акт** | | | | | |
| **Албан шаардлага** | 2 | 392,288.2 | 2 | 392,288.2 | 100,% |
| **Зөвлөмж** | 3 | 751.6 | 3 | 751.6 | 100% |
| **Нийт дүн** | **5** | **393,039.8** | **5** | **392,288.2** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал ажиглагдаагүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,274.5 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснээс 9,274.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

### 5.3 Зөвлөмж

1.Зардлын данстай холбоотой

*Илрүүлэлт:*

Заамар сумын Шижир алт бага сургууль нь хүүхдийн үдийн цайг гэрээгээр ханган нийлүүлдэг боловч хүнсний материалын орц нормын дагуу мөрдөж ажиллаж буй эсэхэд хяналт, шалгалт хийдэггүй 9,274.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Боловсрол шинжлэх ухааны яамны сайд, Эрүүл мэндийн яамны сайд, Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/166 дугаартай хамтарсан тушаалын 1-р хавсралт, 3-р хавсралтыг мөрдөж ажиллах" заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" заалт, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*

Цаашид дээрх тушаалд дурдсан хоолны орц нормыг баримтлан ажиллахыг ахлах тогооч мөрдөж нягтлан бодогч хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Гэрээгээр ажиллуулж байгаа үдийн цай хөтөлбөрийн хоолны орц нормыг хянаж ажиллаагүй | 1 | 9,274.5 | | | | | 1 | 9,274.5 | | | | |
| **Дүн** | **1** | **9,274.5** | | | | | **1** | **9,274.5** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 159 мэдээ оруулахаас1 мэдээ хугацаа хоцроосон | 1 | | | | | | 1 | |
| | | | | | | | | |
| Дүн | 1 | | | | | | 1 | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас:  +976  70272582,  +976  70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn